			<p>бусад хэлбэрээр даатгах чиглэл баримтлан ажиллах нь зүйтэй байна.</p> <p>10. Компанийн 2014 оны давхар даатгалын төлөвлөгөөнд эд хөрөнгийн болон бизнесийн тасалдал, удирдах ажилтны хариуцлагын даатгал, нисэх буудлын хариуцлагын даатгал зэрэг хэлбэрүүдээр фронтинг хийнэ гэж тусгасан боловч олон нийтийн өмнө хүлээх хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, ачаа тээврийн даатгалын хэлбэрээр фронтинг хийсэн байгаа нь Хорооны 2013 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүний биелэлтэнд хяналт тавих журам” –ын 3.10-т “Давхар даатгалын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах зүйлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ тухай хүсэлтээ 10 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэж, шинэчлэгдсэн төлөвлөгөөг ирүүлж, зөвшөөрүүлэх” гэж заасныг зөрчсөн тул уг журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.</p> <p>11. Даатгагчийн даатгалын зуучлагч компанитай байгуулсан гэрээний нөхцөл нь “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл жиллагааг зохистой явуулах журам”-ын 2.1.3: “Даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх”, 2.1.5: “шударга өрсөлдөөнийг эрхэмлэх”, 2.2.2: “.....иргэдэд даатгагчаа чөлөөтэй сонгох боломж, бололцоогоор хангана” гэсэн даатгагчийн баримтлах ёс зүйн заалтуудыг зөрчиж байна. Эдгээр гэрээг шинэчлэн байгуулж, тус журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	
2	“Мөнх даатгал” ХХК	2015.05.19-06.02	<ol style="list-style-type: none"> 1. Компанийн засаглал, ТУЗ, дотоод хяналт, аудитыг сайжруулах; 2. Ус цаг уур, орчны шинжилгээний газартай байгуулсан даатгалын гэрээний хувьд эрсдэлийн төвлөрөл ихтэй байгаа тул давхар даатгуулах; 3. Даатгалын 2015 оны 1 дүгээр улирлын даатгалын нөөц сангуудыг нөхөж байгуулах, 2014 оны актуарын тайлан ирүүлэх; 4. Шүүхээр заргалдаж, шийдэгдээгүй байгаа нэхэмжлэлийн дүнгээр нэхэмжилсэн хохирлын нөөц байгуулах; 5. Төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах төлөвлөгөө боловсруулж ирүүлэх. 	<p>Биелэлт: 100%</p> <p>2015.06.11-ний өдөр нийт 3,700,000 төгрөгөөр торгосон. Торгуулийг 2015.06.12-ны өдөр бүрэн төлсөн.</p> <p>“Мөнх даатгал” ХХК-ийн 2015.06.29-ны өдрийн 01/126 тоотой уурэг даалгаврын биелэлтийг хороонд ирүүлсэн.</p>
3	“Монре даатгал” ХХК	2015.06.15-26	<p>Удирдлага зохион байгуулалт, дотоод хяналтын чиглэлээр - ТУЗ-ын хурлын тэмдэглэл болон шийдвэр дээр хувьцаа</p>	<p>Биелэлт: 70%</p>

		<p>эзэмшигч Р.Туяацэцэг, У.Сийлэн, нягтлан бодогч Т.Сугарсүрэн нэрийн өмнөөс гарын үсэг зурахыг хориглох;</p> <ul style="list-style-type: none"> - Дотоод хяналтын нэгж болон албан тушаалтан томилон ажиллуулах; <p>Даатгалын үйл ажиллагааны чиглэлээр</p> <ul style="list-style-type: none"> - Даатгалын тохиолдол бий болсон тохиолдолд санаатайгаар зайлс хийхгүй байх холбогдох хууль, журмыг гуйвуулж ашиглаж даатгуулагчдыг хохироохгүй байх тал дээр анхаарч ажиллах; - ЖХАЖД-ын хохирол үнэлгээний зардлыг төлж байх; - Даатгалын гэрээний стандарт нөхцөл, шаардлагыг үйл ажиллагаанд мөрдөж ажиллах, гэрээ байгуулж байгаа газарт стандарт нөхцөлийг олон нийтэд ил тод харагдахаар байрлуулах; - Гэрээний үнийн саналыг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж байх; - Зарим даатгалын гэрээний баталгаа нь гарын үсэг дурагдаагүй байгааг цаашид анхаарч ажиллах; - “Монре даатгал” ХХК нь өөрийн http://www.monre.mn/ цахим хуудсанд “Тээврийн хэрэгслийн даатгал”-ын хамрагдахгүй нөхцөл хэсгийг байршуулсан болон зөөврийн компьютерээс нээх тохиолдолд 2 заалт дутуу харагдаж, персонал компьютерээс нээх тохиолдолд бүрэн харагдаж байна. Энэ үйлдэл нь Хорооны 2007 оны 136 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах ёс зүйн журам”-ыг баримтлан ажиллаагүй гэж үзэх нөхцлийг бүрдүүлж байна. Уг зөрчлийн хүрээнд Хорооноос торгуулийн арга хэмжээ авахгүй байхаар бүрдүүлж байна. Уг зөрчлийн хүрээнд Хорооноос торгуулийн арга хэмжээ авахгүй байхаар шийдвэрлээн боловч цаашид уг техникийн алдааг засварлаж, гарсан зөрчлийг арилгах; - Тайланд дурдсан даатгуулагч С.Энхтөр, Д.Энхжаргал болон газар дээрх шалгалтаар ажиллах үед шалгалтын ажлын хэсэгт өргөдөл гаргасан иргэн Г.Ганзориг, Г.Эрдэнэ-Очир нарын даатгалын нөхөн төлбөрийг даатгагч шийдвэрлэсэн боловч хууль болон гэрээгээр хүлээсэн хугацаанд шийдвэрлээгүй үйлдэл нь даатгуулагч, хохирогчийг чирэгдүүлсэн байна. иймд даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж 	<p>2015.08.13 өдрийн 36 тоот зөрчлийн тухай тэмдэглэл, 35815, 35816 тоот шийтгэврийн хуудсаар нийт 4,420,000 төгрөгөөр торгосон. Торгуулийг 2015.08.21-ний өдөр бүрэн төлсөн.</p>
--	--	--	---

		<p>ажиллахыг анхаарах;</p> <ul style="list-style-type: none"> - Даатгалын тухай хуулийн 56.1 дэх хэсэгт “Даатгагч нь даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа, эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээдэд аливаа төлбөр хураамж төлөхийг хориглоно” гэж заасныг баримталж ажиллах; - Хорооны 2011 оны 331 тоот тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын хураамжийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д заасан шаардлагаас зөрүүтэй тооцож даатгалын хураамж авч байгаа зөрчлийг арилгах; - ЖХАЖД-ын гэрээний 9.6 дахь хэсэгт “Даатгуулагч Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.1, 13.4 болон энэ гэрээний 9.2.3-9.2.6, 9.5-д заасан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй улмаас үүсэх үр дагаврыг даатгагч хариуцахгүй бөгөөд хохирлыг даатгагч өөрөө хариуцна” гэж утгын зөрүүтэй хэвлэж даатгуулагчийг төөрөлдүүлсэн хэвлэмэл гэрээ даатгуулагчид тараагдсаар байна. Иймд Даатгалын тухай хуулийн 85.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн төөрөгдүүлсэн гэрээг борлуулахыг зогсоож, яаралтай залруулга хийж, дахин алдаатай хэвлүүлэхгүй байх; - Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд зохих ёсоор биелүүлж, Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах; - Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25.1.3-д “Холбогдох баримт бичгийг хянан үзэх, түүнийг хуулбарлуулан авах” гэж заагдсан хянан шалгагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх шаардлагыг даатгагч биелүүлж ажиллаагүй боловч залруулж материал Хороонд ирүүлсэн. Хойшид шалгалтын хугацаанд шаардсан материал танилцуулж ажиллахыг анхааруулж байна. <p>Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр</p> <ul style="list-style-type: none"> - Нягтлан бодох бүртгэлийн дагаж мөрдөх бодлогын баримт бичиг байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.1-д заасныг зөрчиж байгаа тул яаралтай уг баримт бичгийг боловсруулах; <p>Даатгалын нөөц сан, актуар тооцооллын чиглэлээр</p> <ul style="list-style-type: none"> - 2015 оны 1 дүгээр улирлын байдлаарх УБНХНС-ийн хуваарилалтын зөрүү болох 326,821,857.31 төгрөгийг УБХНС- 	
--	--	---	--

			<p>гаас шилжүүлэн, УБНХНС-гийн эцсийн үлдэгдлийг энэ дүнгээр нэмэгдүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> - Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБНХНС)-ийн тооцооллыг дахин залруулан хийж, залруулгыг Хороонд ирүүлэх; - УБНХНС-ийн тооцоолол болон байгуулалтыг актуар тооцооллын сонгодог зарчим, тодорхой аргачлалын дагуу гүйцэтгэж, энэ нөөц сангийн хэмжээг хүрэлцээтэйгээр байгуулж байх (2013, 2014, 2015 онуудын өгөгдлөөр нөхөн төлбөрийн хөгжлийн гурвалжинг байгуулж, Гинжин шатны арга (Chain Ladder method), Борнхуеттер-Фергюсоны арга (Bornhuetter-Ferguson method) болон бусад аддитив аргуудаас тодорхой 2-3 аргыг сонгож, тооцооллыг гүйцэтгэдэг болох). 	
4	“Гэр даатгал” ХХК	2015.09.29-10.12	<ul style="list-style-type: none"> - Н.Цэлмэгсайханыг компанийн нягтлан бодогчоор ажиллуулахтай холбоотой материалыг журамт заасны дагуу Хороонд ирүүлж, холбогдох зөвшөөрлийг авах; - Тус компанийн шалгалтад хамрагдах хугацаан дахь зардлын харьцаа, хосолсон харьцаа нь боломжит түвшинээс өндөр байна. Энэ нь тус компанийн үйл ажиллагааны зардал, тухайлбал, цалингийн болон даатгалын төлөөлөгчид олгож буй шимтгэлийн зардал өндөр байгаатай холбоотой байх тул дээрх зардлуудыг бууруулж ажиллах; - Мөн өөрт үлдэх эрсдлийн харьцаа 100% буюу боломжит түвшнээс өндөр байх тул тус компани өөрт үлдэх эрсдлийг давхар даатгалд шилжүүлж, компанийн эрсдлийг тараан байршуулах нь зүйтэй; - “Юу жи си” ХХК-тай холбоотой 819,7 мянган төгрөг, Н.Дариймаатай холбоотой 166,9 мянган төгрөг, Я.Чойжилсүрэнтэй холбоотой 255,0 мянган төгрөгийн авлагууд нь шалгалтад хамрагдах хугацаанд төлөгдөөгүй байх бөгөөд дээрх авлагыг барагдуулах, шаардлагатай бол найдваргүй авлага руу шилжүүлж хасагдуулах шаардлагатай; - Нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулж байгаа нь сайшаалтай боловч нөөц сангийн тайлан дахь нэмэгдсэн, хасагдсан дүнгүүд нотлогдохгүй байх тул цаашид нэхэмжилсэн хохирлын нөөц санг зөв тооцоолон байгуулж байх нь зүйтэй; - Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж 	<p>Биелэлт: 95%</p> <p>2015.11.09-ний өдрийн 54 тоот зөрчлийн тэмдэглэлийн хуудас, 2015.11.05-ны өдрийн 35834 тоот шийтгэврийн хуудсаар нийт 2,160,000 төгрөгөөр торгосон. Торгуулийг 2015.11.09-ний өдөр бүрэн төлсөн.</p> <p>“Гэр даатгал” ХХК-ийн 2015.11.20-ны өдрийн 0-144-2015 тоотоор үүрэг даалгаврын биелэлтийг Хороонд ирүүлсэн.</p>

			<p>мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.18 заалтад заасны дагуу актуарчтай болох;</p> <ul style="list-style-type: none"> - Цаашид Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан (УБНХНС) болон учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС)-гийн тооцооллыг дахин тооцоолж, Хороонд ирүүлэх; - Санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлж байх талаар цаашид анхаарч ажиллах; - Улсын бүртгэлийн албанд банкинд байршиж буй харилцах хадгаламжийн дансуудыг бүрэн бүртгүүлэх; - Холбогдох этгээдэд аливаа сангаас зээл олгохгүй байх, аливаа этгээдэд барьцаагүй зээл олгохгүй байх, холбогдох авлагыг бүрэн барагдуулж дуусгах; - Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.5-д заасны дагуу даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг даатгуулагч, хохирогч нарт олгож байх; - Хорооноос даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй этгээдэд аливаа төлбөр хураамж төлөхгүй байх; - ТУЗ-ын гишүүдийг холбогдох журамд заасан сургалтад хамруулж, гэрчилгээ авах, ТУЗ-ын гишүүнээр томилох зөвшөөрлийг Хорооноос авах, - Албан журмын даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд даатгуулагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу гэрээний үлдэх хугацаатай тэнцэх хэмжээний даатгалын хураамжийг хувь тэнцүүлэн тооцож даатгалын буцаалтыг олгож байх; 	
5	“Ард даатгал” ХХК	2015.10.30-11.12	<p>Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр</p> <ul style="list-style-type: none"> - Касс, харилцахын гүйлгээний анхан шатны нотлогдох баримтын бүрдлийг хангаж ажиллах, тухайлбал кассын зарлагын баримтанд олгосон нярав, хүлээн авсан этгээд гарын үсэг зуруулж байх, санхүүгийн тэмдэг дарж баталгаажуулж байх; - Мөнгөн хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, цаашид анхаарч ажиллах, компанийн шат шатны нягтлангуудын ажлын хариуцлагыг дээшлүүлж, байнгын хяналт тавьж байх;\ 	<p>Биелэлт 100%</p> <p>2015.02.22-ны өдрийн 62 тоот зөрчлийн тэмдэглэлийн хуудас, 35848 тоот шийтгэврийн хуудсаар нийт 16,160,000 төгрөгөөр торгосон. Торгуулийг 2016.03.02-ны өдөр бүрэн төлсөн.</p>

			<ul style="list-style-type: none"> - Цаашид холбогдох этгээдэд аливаа сангаас зээл олгохгүй байх, аливаа этгээдэд барьцаагүй зээл олгохгүй байх, аливаа хуулийн этгээд, ажилчдад зээл олгох тохиолдолд өмчлөл дэх Үл хөдлөх хөрөнгийг барьцаалах, Иргэний хуулийн 156 дугаар зүйлд заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж, улсын бүртгэлд бүргүүлж байх, мөн барьцаанд тавигдах эд хөрөнгийн хамтран өмчлөгчөөс итгэмжлэл гаргуулж байх; - Компанийн үйл ажиллагаанд зориулан зээл авах тохиолдолд Даатгалын тухай хуульд заасны дагуу холбогдох зөвшөөрлийг Хорооноос авах; - Нягтлан бодох болон санхүүгийн бүртгэлээ зохих ёсоор хөтлөж байх; - Нөөц сангаас холбогдох журамд заасан ангилал, хэмжээ хязгаарт нийцүүлэн хөрөнгө оруулалт хийж байх; - “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу аливаа даатгалын гэрээг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, валютаар орлого олохгүй байх; - Авлагыг бууруулж, аливаа этгээдэд хөрөнгө удаан хугацаагаар үр ашиггүй ашиглуулахгүй байх, авлагын насжилтын багасгах зорилгоор зээлийн гэрээг байгуулж, Хороог хуурах үйлдлийг гаргахгүй байх; - 2015 оны 4 дүгээр улирлын байдлаар төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангаж, цаашид төлбөрийн чадвараа сайжруулах талаар богино хугацааны төлөвлөгөөг гаргаж танилцуулах; <p>Нөхөн төлбөрийн талаар</p> <ul style="list-style-type: none"> - “Ард даатгал” ХХК нь 2014 оноос “Сонголт софт” ХХК-тай хамтран “Даатгалын мэдээллийн систем 2.0” програмыг ашиглаж мэдээллийн нэгдсэн сан үүсгэхээр зорьж ажиллаж байгаа нь сайн үзүүлэлт боловч тус програмд оруулсан дүн нь компанийн Санхүү бүртгэлийн албанаас гаргасан дүнтэй зөрүүтэй байгааг хойшид анхаарч ажиллах нь зүйтэй - Даатгалын гэрээг зөвхөн англи хэл дээр байгуулсан нь баримтаар нотлогдсон, тодруулбал “Ард даатгал” ХХК нь “М Си Эс кока кола” ХХК-тай ачаа тээврийн даатгалыг 2012.11.21-ний өдөр 0000212 тоот, 2012.12.17-ны өдөр 	<p>“Ард даатгал” ХХК-ийн 2016.02.04-ний өдрийн 02/16/97 тоотуор үүрэг даалгаврын биелэлтийг Хороонд ирүүлсэн. Тайлбарт алдаа дутагдалыг сайжруулж анхаарч ажиллахыг мэдэгдэж, өгсөн үүрэг даалгаврыг 6 бүлгийн 18 зүйлийг нэгтгэж санал ирүүлсэн байна.</p>
--	--	--	--	---

			<p>0000223 тоот, 2013.05.29-ний өдөр 0000269, 00002709 тоот, 2013.06.10-ны өдөр 0000274 тоот, 2013.06.25-ны өдөр 0000289 тоот гэрээнүүдийг англи хэл дээр байгуулж, даатгалын хураамжийг доллараар илэрхийлж байгуулсан, мөн 2015.11.10-ны өдрийн 14 тоотор 204315DC50 тоот даатгалын гэрээг “ЗАГ” ХХК-тай зөвхөн англи хэл дээр байгуулсан тул Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 5.1.1 дэх хэсэгт “Даатгуулагчтай байгуулж байгаа даатгалын гэрээ нь монгол хэл дээр үйлдэгдсэн ... байх” гэсэн даатгалын гэрээнд тавигдах шаардлагыг анхаарч ажиллана уу;</p> <ul style="list-style-type: none"> - Мөн гэрээ байгуулахдаа даатгалын хураамжийг / 0000212 тоот, 0000223 тоот, 0000289 тоот, 0000274 тоот, 204315DC50 тоот/ гадаад валютаар илэрхийлсэн нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд заасан зүйл заалтыг зөрчсөн гэрээ гэж үзэх бөгөөд гэрээг Англи хэл дээр хийх тохиолдолд Монгол хэл дээр мөн хийж, даатгалын хураамжийг төгрөгөөр илэрхийлэхийг цаашид анхаарна уу - Нөхөн төлбөр олгохдоо даатгалын хугацаа дуусаагүй даатгалын гэрээг хураан авч нөхөн төлбөрийн баримттай цуг архивласан нь цаашид даатгуулагчдад даатгалын тохиолдол гарахад дахин нөхөн төлбөр авах боломжийг хаасан байна. Иймд нөхөн төлбөрийн бүрдүүлбэрийг архивлах тохиолдолд гэрээний хуулбарыг авч хадгалахад анхаарна уу; - Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.5 дахь хэсэгт “Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг даатгагч, жолоочийн даатгалын сан хариуцна” гэж заасан боловч даатгалын хохирол үнэлгээний зардлыг даатгуулагч, хохирогчид олгохгүй байгаа тохиолдол олон байгаа тул даатгуулагчид учирсан хохирол зардлыг бүрэн барагдуулж ажиллахыг үүрэг болгож байна; - Хорооноос мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй компанийн хохирлын үнэлгээг 	
--	--	--	--	--

үндэслэн даатгуулагчид нөхөн төлбөр олгосон. Энэ нь Даатгалын тухай хуулийн 56.1 дэх хэсэгт “Даатгагч нь даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээдэд аливаа төлбөр хураамж төлөхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарна уу;

- Хорооны 2011 оны 331 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д заасан шаардлагаас зөрүүтэй тооцож даатгалын хураамж авч байгаа зөрчилд анхаарч ажиллах нь зүйтэй;

Салбарын үйл ажиллагааны чиглэлээр

- Хорооны 2013 оны 198 тоот тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 4.1.1 дэх хэсэгт “Улаанбаатар хот дахь салбарын захирал таван зуун мянган төгрөг хүртэл, хөдөө орон нутаг дахь салбарын захирал гурван зуун мянган төгрөг хүртэл дүнтэй нөхөн төлбөрийг бие даан шуурхай шийдвэрлэдэг байх” гэсэн шаардлагыг ханган, нэн ялангуяа орон нутаг дахь салбарын удирдлага менежрүүдийг чадавхийг нэмэгдүүлэх, даатгалын нөхөн төлбөр олголтыг шуурхай болгож цаашид салбараас нөхөн төлбөр бие даан шийдвэрлэх чадавхи, эрх мэдлийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана уу;
- Салбарын хаягийн өөрчлөлтийг Хороонд мэдэгдэхгүй байгаа нь Хорооны 2013 оны 198 тоот тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 4.1.4 дэх хэсэгт “Салбарын даатгалын үйл ажиллагаа явуулах газрын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд даатгагч ажлын 5 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэж байх” гэсэн шаардлагыг хойшид анхаарах;
- Хорооны 2013 оны 198 тоот тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 5.1.5 дахь хэсэгт “Даатгагч эсхүл түүний төлөөлөгч нь бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгуулагч

нэг бүрт тухайн даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулж, зөвшөөрлийг бичгээр авсан байна” гэж заасныг биелүүлж ажиллахад анхаарах;

Даатгалын нөөц сан, актуар тооцооллын чиглэлээр

- Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын заасны дагуу актуарчтай болох;
- Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС)-гийн тооцооллыг дахин тооцоолж, Хороонд ирүүлэх;

Ил тод нээлттэй байдлын чиглэлээр

- Хорооны 2015 оны 6 дураар сарын 10-ны өдрийн 277 дугаар тогтоолоор Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1 дэх хэсэг, мөн Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.25 дах заалтыг хэрэгжүүлэх;

Удирдлага зохион байгуулалт, дотоод хяналтын чиглэлээр

- Гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гүйцэтгэх захирал болон ТУЗ-ын гишүүний талаар “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын дагуу дүгнэлт гаргуулж ажиллах. Эсвэл уг журмын шаардлагыг хангасан этгээдийг нэн даруй томилох;
- Архивын бичиг баримтыг цэгцтэй, зөв үдэх, товъеог хийх, дугаарлаж байх;
- 2015 оны 3 дугаар сард хийсэн Нөөц сангийн бүрдүүлэлт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хийсэн хэсэгчилсэн шалгалтын тайланд дээрх зөрчлийг 2015 оны 1 дүгээр улирлын тайлангаар арилгах үүрэг даалгавар өгсөн боловч одоог хүртэл арга хэмжээ аваагүй байгааг анхаарах;

Даатгалын үйл ажиллагааны чиглэлээр

- Даатгалын тохиолдол бий болсон тохиолдолд санаатайгаар зайлс хийхгүй байх холбогдох хууль, журмыг гуйвуулж ашиглаж даатгуулагчдыг хохироохгүй байх тал дээр анхаарч ажиллах;
- Даатгалын тухай хуулийн дагуу хохирол үнэлэгчийн

			<p>бичгээр гаргасан хохирлын хэмжээг үндэслэлгүйгээр бууруулахгүй байх, тус Хорооноос тусгай зөвшөөрөл авсан хохирол үнэлэгчийн дүгнэлтийг ашиглах нөхөн төлбөр олгож байх;</p> <ul style="list-style-type: none"> - Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хохирол үнэлгээний зардлыг төлж байх; - Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор баталсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 4.1.1- д заасан “Улаанбаатар хот дахь салбарын захирал 500 мянган төгрөг хүртэл, хөдөө орон нутаг дахь салбарын захирал 300 мянган төгрөг хүртэл дүнтэй нөхөн төлбөрийг бие даан шуурхай шийдвэрлэнэ гэсэн заалтыг мөрдөж ажиллах Даатгалын гэрээний стандарт нөхцөл, шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж, гэрээ байгуулж байгаа газарт стандарт нөхцөлийг олон нийтэд ил тод харагдахаар байрлуулах; - Гэрээний үнийн саналыг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж байх - Зарим даатгалын гэрээ нь дугаар байхгүй, огноо байхгүй, гарын үсэг зурагдаагүй байгааг цаашид анхаарч ажиллах; - 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.18-д заасны дагуу шаардлага хангасан эрхтэй актуарчтай байх; - Давхар даатгалын төлөвлөгөөг шаардлагын хэмжээнд боловсруулж байх, өөрийн хүлээж чадах алдагдлын хязгаарыг активын хэмжээгээр бус санхүүгийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахааргүй хэмжээгээр тогтоон уг хязгаараас давсан гэрээг давхар даатгалд хамруулж байх; - Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд зохих ёсоор биелүүлж, Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах; 	
6	“Миг даатгал” ХХК	2016.02.22-03.01	<ul style="list-style-type: none"> - ТУЗ-ын дарга У.Бямбасүрэн, гишүүн Ж.Бат-Орших нарын материалыг Хороонд ирүүлж, холбогдох зөвшөөрлийг авах; - Касс, харилцахын гүйлгээний анхан шатны нотлогдох баримтын бүрдлийг хангаж ажиллах, тухайлбал кассын зарлагын баримтанд олгосон нярав, хүлээн авсан этгээд гарын 	Биелэлт: 100% Тайланг “Миг даатгал” ХХК-д хүргүүлсэн бөгөөд тайлбар ирүүлсэний дараагаар Зөрчлийн тэмдэглэл, шийтгэврийн

		<p>үсэг зуруулж байх, 2013, 2014, 2015 онуудын кассын болон нөхөн төлбөрын баримтуудыг дугаарлалттай болгох;</p> <ul style="list-style-type: none"> - Дүрмийн санг нэмэгдүүлэхдээ Хорооноос зөвшөөрөл аваагүй байгаа нь Даатгалын тухай хуулийн 21.3-т заасныг зөрчсөн байх тул Хорооноос өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох залруулгыг хийж, Хороонд хүргүүлэх. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Хорооны санхүү тайлагналын цахим Фина системд залруулга хийх; • 2015 оны 4 дүгээр улирлын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланд залруулга оруулж Хороонд ирүүлэх; • Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг сонинд нийтлүүлж, Хороонд ирүүлэх. - Цаашид аливаа этгээдэд барьцаагүй зээл олгохгүй байх, аливаа хуулийн этгээд, ажилчдад зээл олгох тохиолдолд өмчлөл дэх Үл хөдлөх хөрөнгийг барьцаалах, Иргэний хуулийн 156 дугаар зүйлд заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж, улсын бүртгэлд бүргүүлж байх, мөн барьцаанд тавигдах эд хөрөнгийн хамтран өмчлөгчөөс итгэмжлэл гаргуулж байх; - Анод банкнаас гаргасан 50,050,000 төгрөгийн үнэт цаасыг Орон нутгийн засаг захиргааны бонд болон Банкны хадгаламжийн сертификатаар давхар бүртгэсэн байгаа нь санхүүгийн тайлангийн дүн буруу гарахаас гадна санхүүгийн хэрэглэгчдийг бодит бус мэдээллээр хангаж байгаа тул цаашид мөнгөн хөрөнгийн бүртгэл, түүний хяналтыг сайжруулж, мөнгөн хөрөнгийн байршлын мэдээллийг үнэн зөвөөр тайлагнаж байх; - “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу валютаар орлого олохгүй байх; - Тус компанийн өөрт үлдэх эрсдлийн харьцаа 3 жилийн хугацаанд өсөх хандлагатай байх тул өөрт үлдэх эрсдлийг сайтар тооцоолж, компанийн эрсдлийг тараан байршуулахад анхаарч ажиллах; - Тус компанийн УБНХНС-г байгуулахад тооцоолсон актуар тооцооллыг Хороонд ирүүлж хянуулах; - Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж 	хуудсыг даатгагчид өгөх болно.
--	--	--	--------------------------------

			<p>мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.18 заалтад заасны дагуу актуарчтай болох;</p> <ul style="list-style-type: none"> - Даатгуулагч “Шангрила Улаанбаатар Зочид буудал” ХХК-д учирсан даатгалын тохиолдолд Хорооны 2009 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу УБНХНС-г байгуулж ажиллах үүрэг өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байх тул дээрх нөөц сантай холбоотой тайлбарыг Хороонд ирүүлэх - “Лимитед II” тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ болон “Миг даатгал” ХХК-ийн http://mig.mn/ цахим хуудсанд тээврийн хэрэгслийн эд зүйлсийг алдах тохиолдолд нь даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах тухай олон нийтэд мэдээлж ажиллах нь зүйтэй. Учир нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан баримт материалын багагүй хувийг хулгайд эд зүйлсээ алдсан өргөдөл гомдолууд эзлэж байгааг анхаарах; - 2014.12.22-ны өдрийн 14/271 тоот гэрээг “Чрезвычайный и Полномочный Посол Российской Федерации в Монголий” байгууллагатай байгуулахдаа гэрээг зөвхөн Орос хэл дээр байгуулж, даатгалын үнэлгээг, хураамжийг доллараар илэрхийлсэн нь Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 5.1.1 дэх хэсэгт “Даатгуулагчтай байгуулж байгаа даатгалын гэрээ нь монгол хэл дээр үйлдэгдсэн байх” гэсэн даатгалын гэрээнд тавигдах шаардлагыг, мөн гэрээ байгуулахдаа даатгалын хураамжийг гадаад валютаар илэрхийлсэн нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд заасан зүйл заалтыг хангаж ажиллахад анхаарах; - Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.5 дахь хэсэгт “Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг даатгагч, жолоочийн даатгалын сан хариуцна” гэж заасныг зөрчсөн бөгөөд Хорооноос 2013 оны 4 дүгээр сард “Миг даатгал” ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн өмнөх газар дээрх шалгалтаар энэ зөрчлийг мөн давтаж байсныг анхаарч 	
--	--	--	---	--

			<p>ажиллах шаардлагатай. Түүнчлэн тус шалгалтын тайлангийн 8- “Даатгалын нөхөн төлбөрийн тухай” бүлгийн 3 дахь хэсэгт дурдсан даатгуулагч нараас илүүгээр тооцож авсан даатгалын хураамжийн хэсгийг буцаан олгох;</p> <ul style="list-style-type: none">- Үндэслэлгүйгээр даатгалын нөхөн төлбөрийг буруулж олгосон нь Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам” –ын 5.2.2 дахь заалтыг зөрчиж байх Даатгалын тухай хуулийн 8.4 болон холбогдох журамд заасны дагуу даатгагчид нөхөн төлбөрийг олгож байхыг анхаарч, тус шалгалтын тайлангийн 8- “Даатгалын нөхөн төлбөрийн тухай” бүлгийн 4 дэх хэсэгт дурдсан даатгуулагч нарын даатгалын нөхөн төлбөрийн бүрэн олгох, эсвэл буруулж олгосон тайлбарыг Хороонд ирүүлэх;- Хорооны 2011 оны 331 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д заасан шаардлагын дагуу тооцоолоход хяналт тавьж ажиллана уу, Нэн ялангуяа орон нутгийн төлөөлөгч болон зуучлагч нарын гэрээнд илүү анхаарах;- Хорооны 2013 оны 198 тоот тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 4.1.1 дэх хэсэгт “Улаанбаатар хот дахь салбарын захирал таван зуун мянган төгрөг хүртэл, хөдөө орон нутаг дахь салбарын захирал гурван зуун мянган төгрөг хүртэл дүнтэй нөхөн төлбөрийг бие даан шуурхай шийдвэрлэдэг байх” гэсэн шаардлагыг ханган, нэн ялангуяа орон нутаг дахь салбарын удирдлага менежерүүдийн эрх мэдэл, чадавхийг нэмэгдүүлэх, даатгалын нөхөн төлбөр олголтыг шуурхай болгож ажиллах;- Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.8² дахь хэсэгт “Даатгалын компанийн салбар нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд шуурхай албатай байх...”, Хорооны 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 2.5 дахь хэсэгт “Жолоочийн даатгалын	
--	--	--	--	--

			<p>тохиолдлыг шалгах шуурхай албатай байх” гэж заасныг тус тус биелүүлж ажиллах шаардлагатай байна.</p> <ul style="list-style-type: none"> - Компанийн санхүүгийн баримтыг хадгаламжийн нэгж болгон хадгалахдаа хуудас бүрийг дугаарлан, товъёог хийн хадгалж байх; - Даатгалын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа даган мөрдөж ажиллаж. 	
7	“Хаан даатгал” ХХК	2015.03.16-27	<ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээнд хаягийн өөрчлөлт, орон нутаг дахь салбарууд болон бүртгэгдээгүй банкны харилцах дансны бүртгэл зэргийг бүртгүүлэх; - Гэрээний үнийн санал, төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж гүйлгээ хийж байх; - Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хохирол үнэлгээний зардлыг төлж байх; - Тээврийн хэрэгслийн даатгалын болон Хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан иргэд, байгууллагад өөрийн цахим хуудас, нэгжүүдэд танилцуулга, самбар гаргах зэргээр танилцуулга гаргаж, олон нийтэд танилцуулах арга хэмжээ авах; - Аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг Нябо бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороонд ирүүлж, мөн тухайн оны 1 дүгээр улиралд багтаан өдөр тутмын хэвлэл мэдээлэлд нийтлэх; - Нөхөн төлбөр олгох, санхүүгийн шилжүүлэг хийхэд гүйцэтгэх захирлын тушаал гаргаж байх; - Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах; - Нөөц сангийн хөрөнгийн байршлыг алдагдуулахгүй байх; - Дотоод хяналтын нэгжийг ажиллуулах; - Компанийн улирал бүрийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлэх; - Банкны харилцах, хадгаламжийн дансыг шинээр нээх, хаахдаа УБГэрчилгээнд бүртгүүлэх; - Дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг барьцаалах, шилжүүлэх зэргээр захиран зарцуулалт хийхдээ Даатгалын тухай хуулийн 21.3-д заасны дагуу Хорооноос зөвшөөрөл авч байх; - Даатгалын тухай хуулийн 27.1.3-д зааснаар аливаа этгээдэд барьцаагүй зээл олгохгүй байх; 	<p>Биелэлт: 95%</p> <p>2015.04.08 өдрийн 15 тоот зөрчлийн тухай тэмдэглэл, 35793 тоот шийтгэврийн хуудсаар 3.400,000 төгрөг, 960,000 төгрөгөөр тус тус торгосон. Торгуулийг 2015.04.20-ны өдөр бүрэн төлсөн.</p> <p>“Хаан даатгал” ХХК-ийн 2015.05.01-ний өдрийн 4/204 тоотор Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Хороонд ирүүлсэн.</p>

			<ul style="list-style-type: none"> - Компанийн хөрөнгийг эрх бүхий этгээдийн шийдвэр болон зээл олгосон, өгсөн баримтгүй, барьцаа хөрөнгөгүйгээр даатгалын нөөц сангийн хөрөнгийг зарцуулалт хийхгүй байх; - НББ-ийн тухай хуулийн дагуу бүртгэлийг зохих ёсоор бүртгэх; - Нөөц санг байгуулахад ашиглаж байгаа тоон мэдээ, актуар тооцооллын аргачлалаа сайжруулж, нөөц санг бодитойгоор журамд нийцүүлэн байгуулж ажиллах; - Ерөнхий нягтлэн бодогч, нягтлан, няравт тавих хяналтыг сайжруулах, банкны харилцах хадгаламжийн дансны хуулгыг бүртгэлийг тулгаж шалгаж байх; - 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.18-д заасны дагуу шаардлага хангасан актуарчтай байх. Актуарын тайланг хуулийн хугацаанд ирүүлэх; - Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд зохих ёсоор биелүүлж, Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах; - Шалгалтын ажлын хэсэгт ашиглуулсан интернет банкны харилцах, хадгаламжийн дансны орох эрх, нууц үгийг өөрчлөх; 	
8	“Бодь даатгал” ХХК	2015.05.04-15	<p>Удирдлага зохион байгуулалт, дотоод хяналтын чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - Бодь даатгал” ХХК нь компанийн дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 14-а тоот шийдвэрээр батлуулан мөрдөж байгааг Компанийн дүрмийг, компанийн хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгийг шинэчлэн тогтооцон, дотоод хяналтын нэгж байгуулсан боловч чиг үүргийн талаар зэрэг тусгагүй дутагдлууд байна; - Тус компанийн ТУЗ-ийн 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 15-01 тоот тогтоолоор зохион байгуулалтын бүтцээр батлагдсан Аудитын хороог ажиллуулах; - Улсын бүртгэлийн гэрчилгээнд хаягийн өөрчлөлт, орон нутаг дахь салбарууд болон бүртгэгдээгүй банзны харилцах дансны бүртгэл зэргийг бүртгүүлэх; - Гүйцэтгэх удирдлагаар томилогдсон ерөнхий захирал, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч нарын талаар “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын дагуу дүгнэлт гаргуулж ажиллах; 	<p>Биелэлт: 97%</p> <p>2015.06.18 өдрийн 32, 33 тоот зөрчлийн тухай тэмдэглэл, 35811, 35812 тоот шийтгэврийн хуудсаар 100,000 төгрөг, 7,460,000 төгрөгөөр тус тус торгосон. Торгуулийг 2015.07.03-ны өдөр бүрэн төлсөн.</p> <p>“Бодь даатгал” ХХК-ийн 2015.07.20-ны өдрийн 03/920 тоотой Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Хороонд ирүүлсэн.</p>

		<ul style="list-style-type: none"> - “Бодь даатгал” ХХК, АЖДХ-той хамтран ажиллах байгуулсан гэрээг дүгнэх; - “Бодь даатгал” ХХК-ний гүйцэтгэх захирлын 2012 оны 031141 тоот тушаалаар батлагдсан “Бодь даатгал” ХХК-ийн орон нутгийн салбарын шуурхай албаны чиг үүрэг, ажиллах журам”-ыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх; - Архивын бичиг баримтыг цэнцтэй, зөв үдэх, товьеог хийх, дугаарлаж байх; - 2015 оны 3 дугаар сард нийсэн Нөөц сангийн бүрдүүлэлт, хөрөнгө оруулалтын ажиллагаанд хийсэн хэсэгчилсэн шалгалтын тайланд дээрх зөрчлийг 2015 оны 1 дүгээр улирлын тайлангаар арилгах үүрэг даалгавар өгсөн боловч одоог хүртэл арга хэмжээ аваагүй байгаа нь Даатгалын тухай хуулийн 73.3 “Энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгагч биелүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна. Хариуг ирүүлээгүй тохиолдолд албадлагын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн болохыг анхаарна уу. <p>Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.</p> <ul style="list-style-type: none"> - Даатгалын тухай хуулийн 27.1.3-д зааснаар аливаа этгээдэд барьцаагүй зээл олгохыг зогсоох; - Компанийн хөрөнгийг эрх бүхий этгээдийн шийдвэр болон зээл олгосон, өгсөн баримтгүй, барьцаа хөрөнгүйгээр даатгалын нөөц сангийн хөрөнгийг зарцуулалт хийхгүй байх. - Зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллах. Хугацаа хэтэрсэн зээлүүдийг хаах, эргэн төлүүлэх тал дээр холбогдох арга хэмжээ авч ажиллах; - Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгө хэсэгт тусгагдсан 1,187,7 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг компанийн нэр дээр шилжүүлэх; - Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах; - НББ-ийн тухай хуулийн дагуу бүртгэлийг зохих ёсоор бүртгэх; - Банкны харилцах, хадгаламжийн дансыг шинээр нээх, хаахдаа Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлж байха; - Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах; <p>Даатгалын үйл ажиллагааны чиглэлээр</p>	
--	--	---	--

		<ul style="list-style-type: none"> - Даатгалын тохиолдол бий болсон тохиодолд санаатайгаар зайлс хийхгүй байх холбогдох хууль, журмыг гуйвуулж ашиглаж даатгулагчдыг хохироохгүй байх тал дээр анхаарч ажиллах; - Даатгалын тухай хуулийн дагуу хохирол үнэлэгчийн бичгээр грагасан хохирлын хэмжээг үндэслэлгүйгээр бууруулахгүй байх, тус Хорооноос тусгай зөвшөөрөл авсан хохирол үнэлэгчийн дүгнэлтийг ашиглах нөхөн төлбөр олгож байх; - Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хохирол үнэлгээний зардлыг төлж байх; - Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 4.1.1-д заасан “Улаанбаатар хот дахь салбарын захирал 500 мянган төгрөг хүртэл, хөдөө орон нутаг дахь салбарын захирал 300 мянган төгрөг хүртэл дүнтэй нөхөн төлбөрийг бие даан шуурхай шийдвэрлэнэ” гэсэн заалтыг мөрдөж ажиллах; - Даатгалын гэрээний стандарт нөхцөл, шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, гэрээ байгуулж байгаа газарт стандарт нөхцөлийг олон нийтэд ил тод харагдахаар байрлуулах; - Гэрээний үнийн саналыг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж байх; - Зарим даатгалын гэрээ нь дугаар байхгүй, огноо байхгүй, гарын үсэг зурагдаагүй байгааг цаашид анхаарч ажиллах; - 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.18-д заасны дагуу шаардлага хангасан эрхтэй актуарчтай байх; - Давхар даатгалын төлөвлөгөөг шаардлагын хэмжээнд боловсруулж байх, өөрийн хүлээж чадах алдагдлын хязгаарыг активын хэмжээгээр бус санхүүгийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахааргүй хэмжээгээр тогтоон уг хязгаараас давсан гэрээг давхар даатгалд хамруулж байх; - Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд зохих ёсоор биелүүлж, Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах <p>Даатгалын нөөц сан, актуар тооцооллын чиглэлээр</p> <ul style="list-style-type: none"> - Даатгагч нь ОТХНС болон ОТХО-ыг зөв тодорхойлоогүй, 	
--	--	---	--

			<p>тооцооллын эмх журамгүй байдлыг бий болгосон, актуар тооцооллын зарчим, аргачлалд үндэслэн УБНХНС-ийн тооцоолол болн байгуулалтыг гүйцэтгээгүйгээр нөөц сангийн тодорхойгүй байдлыг бий болгосон нь цаашид төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх магадлалтай байна. Мөн даатгагчаас Хороонд Fina тайлагналын системээр тайлагнасан 2013 оны мэдээллийг ашиглан, нөөц санг тооцоолон шалгахад тайлагналын дүн их хэмжээгээр зөрж байгаа нь Хорооны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл” журмын 2.1.1, 2.1.2, 2.1.6 заалтуудын нөхцөл бүрдсэн болохыг анхааруулж, дор дурдсан зөрчлүүдийг арилгах үүрэг даалгавар өгч байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ОТХНС-ийн тооцооллыг алдаагүй зөв гүйцэтгэж, тайлагнах; - ОТХО-ын тооцооллыг алдаагүй зөв гүйцэтгэж, тайлагнах; - 2013 оны 2, 3, 4 дүгээр улирлуудын ОТХО болон УБНХНС-аас олгосон нөхөн төлбөрүүдийн талаарх өгөгдөл, мэдээлэл, тооцооллыг нөхөж бүрдүүлэн, 2014 оны УБНХНС, УБХНС-уудын тооцоолол, тайлагналыг зөв болгох; - УБНХНС-ийн тооцоолол болон байгуулалтыг актуар тооцооллын зарчим, тодорхой аргачлалын дагуу гүйцэтгэх (2013, 2014, 2015 онуудын өгөгдлөөр нөхөн төлбөрийн хөгжлийн гурвалжинг байгуулж, Гинжин шатны арга (Chain Ladder method), Борнхуеттер-Фергюсоны арга (Bornhuetter-Ferguson method) болон бусад аддитив аргуудаас тодорхой 2-3 аргыг сонгож, тооцооллыг гүйцэтгэдэг болох); - Мөн Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3.1.18-д заасан Хорооноос зөвшөөрөл авсан актуарчтай ажиллах. 	
9	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	2015.06.15-	<ol style="list-style-type: none"> 1. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн шинэчлэгдсэн хаягийг бүртгүүлэх; 2. Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг тодорхой болгож, Хороонд бүртгүүлж байх. 3. Компанийн засаглалыг сайжруулах, Дотоод хяналтын алба байгуулж, биелэлтийг Хороонд хариу мэдэгдэх; 4. Компаниас гарч буй зардалд удирдлагаас тавиж буй хяналтыг сайжруулах, хөрөнгө, мөнгөний захиран зарцуулалт, өглөг авлагын баримт, анхан шатны баримт буюу кассын бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ иж бүрэн, нотлогдох баримтыг 	<p>Биелэлт: 88%</p> <p>2015.08.24-ний өдрийн 38 тоот зөрчлийн тухай тэмдэглэл, 35821 тоот шийтгэврийн хуудсаар нийт 1,460,000 төгрөгөөр торгосон. Торгуулийг 2015.08.31-ний өдөр бүрэн төлсөн.</p>

		<p>бүрэн бүрдүүлж байх;</p> <ol style="list-style-type: none">5. Компанийн санхүүгийн баримтыг хадгаламжийн нэгж болгон хадгалахдаа хуудас бүрийг дугаарлан, товъёог хийн хадгалж байх;6. Авлагын насжилтыг үнэн зөв тайлагнаж, НББ-ийн хуулийн дагуу бүртгэж байх.7. Холбогдох этгээдэд зээл олгохыг зогсоох.8. Аливаа этгээдэд барьцаагүй зээл олгохгүй байх;9. Тусгай зөвшөөрөлгүй даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээдэд аливаа төлбөр хураамж төлөхгүй байх;10. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын даатгуулагчид нөхөн төлбөртэй хамт хохирол үнэлгээний зардлыг олгож байх.11. Даатгалын тохиолдлын хохирлыг хохирогчид бус даатгуулагчид олгож байх.12. Даатгалын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа даган мөрдөж ажиллаж байх;	<p>“Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн 2015.11.09-ний өдрийн 1-2/202 тоотойр Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлсэн.</p>
--	--	--	--